

World Economic Development and its Factories Changes, Summary for Dynamic of Historical Path

Amarjargal Rinchinnyam ^{1*}, Davaadorj Tsedevsuren ²

¹ PhD, Professor, University of Finance and Economics, Ulaanbaatar, Mongolia

² ScD, Honorary Professor, University of Finance and Economics, Ulaanbaatar, Mongolia

*Corresponding Author: Amarjargal Rinchinnyam, E-mail: amarjargal.r@ufe.edu.mn

Received: 28 February 2026 / Accepted: 21 May 2026 / Published online: 29 June 2026

Key words: Economic growth, growth rate, Free market, Capital accumulation, Monopoly, Government intervention

©2026, Author(s)



Abstract: The history of global economic development is commonly studied by aligning it with the Christian era and dividing it into five major stages. The earliest period, characterized by extremely backward and traditional forms of economy, lasted for nearly thirteen centuries. The economy of the Middle Ages, which served as a precursor to the rapid development of the global economy, spanned almost five hundred years.

Sustained and high-speed global economic development was made possible by the industrial revolutions. The era of capital accumulation, free markets, and competitive capitalism—successfully utilizing the achievements of these revolutions—lasted for more than two centuries and created the highest level of economic development in human society, shaping the general pattern of modern life.

In today's information age, large-scale and innovative developments unfolding worldwide increasingly require highly concentrated material and financial resources. As a result, the economic role of enormous transnational and monopolistic business corporations, as well as that of governments, has grown significantly. There is a noticeable tendency toward the contraction of economic democracy, with declining economic participation by ordinary citizens across nations. This trend may adversely affect future global economic development and expansion.

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ, ХҮЧИН ЗҮЙЛҮҮДИЙН ӨӨРЧЛӨЛТ, ДИНАМИКИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛЫН ТУХАЙ ТОВЧЛОЛ, ДҮГНЭЛТҮҮД

1. Дэлхийн эдийн засгийн хөгжлийн үе шат, ерөнхий тойм

Дэлхийн эдийн засгийн хөгжлийн түүхийн эхлэлийг ихэвчлэн шинэ тооллын эхлэлтэй зэрэгцүүлэн судалдаг. Дэлхийн соёл иргэншил болон эдийн засаг нь хоорондоо нягт холбоотой, эргэх холбооны эерэг хамааралтай хөгжил дэвшлийн гол үзүүлэлтүүд боловч түүхчид эрдэмтэд дэлхийн соёл иргэншлийн түүхийг урт хугацааг хамруулан асар олон улс гүрнүүдийн онцлогийг нягтлан судалдаг заншилтай. Хүн нийгмийн эдийн засгийн хөгжлийн түүхийг шинэ тооллоор хязгаарлан судалдгийн учир нь үүнээс өмнөх урт удаан үеийн эдийн засгийн ерөнхий төрх байдал нь шинэ тооллын эхэн үеийнхтэй нэн төстэй, хоцрогдмол мөн чанар, хэлбэрээр үргэлжилж байснаар тайлбарладаг. Эдийн засгийн судлаачдын дүгнэлтээр бол шинэ тооллын ихэнх хугацаа буюу бараг 16-18 зуун жилийн турш дэлхийн эдийн засаг тоон үзүүлэлтийн хувьд ялимгүй өсөн нэмэгдсэн боловч бүтэц, динамикийн хувьд хуучин, хоцрогдсон хэлбэрээр үргэлжилсээр иржээ.

Эдийн засгийн түүх судлаачид хүн нийгмийн эдийн засгийн хөгжлийн динамик явцыг дараах үе шат болгон хуваан авч үзэн судалдаг. Үүнд:

1. Эрт дээр үеийн, нэн хоцрогдмол уламжлалт эдийн засаг
2. Дундад зууны үеийн эдийн засаг
3. Аж үйлдвэрийн капитализм буюу зах зээлийн эдийн засгийн түгээмэл дэлгэрэлтийн үе
4. Орчин үеийн мэдээллийн ба холимог олон хэлбэрт эдийн засгийн үе

Эдийн засгийн хөгжлийн эдгээр үе шатууд нь дэлхийн эдийн засгийн ерөнхий хандлага, олон улс гүрнүүдийн соёл иргэншлийн хөгжлийн гадаад ба дотоод нөхцөл байдлаас шалтгаалан харилцан адилгүй хугацаагаар үргэлжилжээ.

Ялангуяа, дэлхийн эдийн засгийн хөгжлийн эхэн үе буюу анхан шатанд хүмүүн нийгмийн эрхэлж байсан уламжлалт хөдөө аж ахуй нь хөгжил дэвшлийн дорвитой потенциалгүй байсан учраас асар олон зуун жил нэг хэв маягаараа үргэлжилсэн түүхтэй. Уламжлалт хөдөө аж ахуй нь хүмүүсийн амьдрах, амиа зогоох төдийхөн буюу гол төлөв хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэлбэртэй бөгөөд ихэнхдээ байгаль орчны таатай нөхцөлд тулгуурласан, нэн хоцрогдмол байсан.

Ерөнхийдөө шинэ тооллын эхэн үеийн хүн төрөлхтний эрхэлж эхэлсэн эдийн засаг нь гол төлөв гэр аж ахуйн шинжтэй, эдийн засаг хэмээх нэршлийн утга ойлголтуудыг бүрэн илэрхийлэх боломжгүй, бүдүүлэг, хоцрогдмол хэлбэр бөгөөд энэ үе шатанд хүн нийгмийн аж төрөх, амьдрахад таатай байгалийн нутаг дэвсгэрийг эрэлхийлэн суурьших их нүүдэл ч бүрэн дуусаагүй байсан бололтой. Энэ үед эдийн засаг хэмээх үйл ажиллагааны ойлголтын чухал хэсэг болох ховордмол нөөцийн ашиглалтыг сайжруулах болон сонголтын хувилбарын тухай асуудлууд ч хараахан үүсээгүй гэж үзэж болохоор байна.

Дэлхийн олон улс гүрнүүдийн хүн амын тоо, нягтаршил нь харилцан адилгүй байсан бөгөөд азийн өмнөд хэсгийн дулаан нутаг болон газрын дундад тэнгисийн эргэн тойрон дахь нутгууд, Европын баруун хэсэг, Атлантын далайн эргүүдийн улс гүрнүүд харьцангуй олон хүн амтай байжээ. Тэр үед эдийн засгийн үйл ажиллагааны гол субъект нь хүмүүс өөрсдөө байсан ба нөлөөлөх үндсэн хүчин зүйлс нь ч мөн хүмүүс байсан тул олон хүн амтай, нягтаршил өндөртэй улс гүрнүүд бусдаасаа илүү, өндөр хөгжлийн түвшинд хүрсэн нь мэдээж юм. Өөрөөр хэлбэл, тэр үеийн улс гүрнүүдийн эдийн засгийн хөгжил, потенциалын түвшинг хүн амын (олон, цөөн) тоогоор баримжаалан илэрхийлж болно. Иймэрхүү байдал бараг дундад зууныг дуустал үргэлжилсэн бөгөөд эдийн засгийн өсөлтийн гол хүчин зүйл нь хүмүүсийн тоо буюу энэ нь ихэнх тохиолдолд байгаль дэлхийн таатай орчноос шалтгаалдаг байжээ. Эдийн засгийн хөгжлийн чиг баримжааг (нэг хүнд ногдох бүтээгдэхүүний хэмжээ) графикаар илэрхийлбэл бараг хэвтээ маягаар үргэлжилсэн шугам хэлбэртэй байна. Харин дэлхий нийтийн эдийн засгийн өсөлт тэлэлтийн график нь ялимгүй дээшлэх чиглэлтэй шулуун шугам хэлбэрээр илэрхийлэгдэнэ.

Эрт дээр үеийн дэлхийн эдийн засгийн хөгжлийн төв нь ази тив байсан ба хүн ам хамгийн олон тоотой Хятад, Энэтхэг, Япон зэрэг улсууд хамаарагдана. Нийлбэр дүнгээр бараг дундаж зууныг дуустал дэлхийн эдийн засгийн бараг тал хэсгийг Энэтхэг ба Хятадын эдийн засаг эзэлж байжээ. Гэхдээ хүн ам хэт нягтралтай нөхцөлд ганц төрлийн хөдөө аж ахуйтай эдийн засаг нь нөхцөлд давуу тал гэхээсээ илүү хоцрогдол, эдийн засгийн хөгжлийн удааширлын эх уурхай болж хувирдаг жамтай ажээ.

Хүснэгт 1. Азийн том гүрнүүдийн хүн амын тоо (сая хүн)

Улс гүрнүүд	0 - Шинэ тооллын эхлэл	1000 он	1500 он	1600 он	1700 он
Хятад	59,6	59,0	103,0	160,0	138,0
Энэтхэг	75,0	75,0	110,0	135,0	165,0
Япон	3,0	7,05	15,4	18,5	27,0
Бусад орнууд	36,6	41,4	55,4	65,0	71,8

Эх сурвалж: The World Economy “A Millennial Perspective” Angus Madisson (2001)

Дундад зуунд баруун европын хүн ам 100 сая орчим байсан ч дэлхий нийтийн эдийн засгийн хөгжлийн явцад томоохон өөрчлөлтүүдийг оруулжээ. Дундад зуунд феодализм хэмээх хүн нийгмийн соёл иргэншлийн үе бүрэлдэн тогтож, хамжлагат ёс Европын бараг бүх улс орнуудыг хамарчээ. Хамжлагат ёс нэвтэрснээр улс орнуудын хүн ам гурван анги хэсэгт хуваагдаж, дээд буюу дарангуйлагч анги феодалууд газар нутаг болон түүн дээр амьдарч ажиллаж буй бүх хүмүүсийг захиран удирдаж, санваартнууд сүм хийдийн лам нар онцгой эрх дархтай болжээ. Хүн амын ихэнх нь тариачид байсан ба ажил хөдөлмөрийн үр өгөөжөө феодал ангид шилжүүлэн өгдөг эдийн засгийн амьдралын хэв маяг тогтсон байжээ.

Нөгөө талаар баруун Европ нь газар зүйн хувьд сэрүүн бүсэд хамаарагдах тул хүмүүсийн хэрэглээ харьцангуй өргөн хүрээтэй, хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ их байсан нь ойлгомжтой.

Соёл иргэншлийн судлаач Тойнбигийн дүгнэснээр хүн нийгмийн соёл иргэншлийн эволюци хөгжлийн түлхүүр хүчин зүйл бол “шаардлага, хэрэглээ” юм. (Тойнби, 2002). Энэ нь хүний амьдралын бодит шаардлагууд эдийн засгийн хэллэгээр бол “эрэлт” байсан нь ойлгомжтой. Энэхүү “философийн” дагуу баруун Европын хүмүүсийн хэрэглээ, хүрээ хэмжээ нь яваандаа зөвхөн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр хязгаарлагдсангүй бусад олон төрлийн үйл ажиллагааг эрхлэхийг бодит ёсоор шаардаж байсан хэрэг. Энэ шалтгаанаар дундад зууны үед баруун Европт хотжилт хэмээх соёл иргэншлийн томоохон үйл явдал өрнөн дэлгэрч, худалдаа арилжаа өргөжин хүмүүсийн хөдөлгөөн ч үлэмжхэн өрнөжээ. Мөн баруун Европ нь баруун ба өмнөд хэсгээр далайгаар хүрээлэгдсэн нь эдгээр үйл явдлуудыг өрнүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн.

Баруун Европын улс орнуудын байршлыг газрын зургаас харвал аль ч нутаг дэвсгэр нь далайгаас 300-350 км-ээс илүү холгүй оршдог бөгөөд дундад зуунд Энэтхэг, Хятадтай худалдааны харилцаагаа эрс өргөтгөсөн. Мөн Америк тивийг нээж хөгжлийн их потенциалтай болжээ. Нөгөө талаар феодалын аж ахуйн систем хүн нийгмийн түүхэнд нэмэгдэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг бий болгосон бөгөөд энэ нь натурал бүтээгдэхүүний солилцоог өргөжүүлэхийн зэрэгцээгээр цаашдаа худалдаа наймаа эрхлэх, яваандаа гадаад худалдааг хөгжүүлэх боломжийг хангажээ.

Ялангуяа мөнгө хэмээх бүх нийтийн арилжааны ба хуримтлалын хэрэгсэл буй болсон нь эдийн засгийн хөгжлийн нэгэн гол түлхүүр хүчин зүйл болжээ. Дундаж зуунд Европт хөдөө аж ахуйн зэрэгцээгээр хүмүүсийн үйл ажиллагааны олон хэлбэрүүд эдийн засгийн биеэ даасан салбарууд болон хөгжиж эхэлжээ. Х зуун гэхэд Европын улс гүрнүүдийн хил хязгаар тодорч тэдгээрийн нийслэл хотууд хэмээх ойлголт буй болж эдийн засгийн “шаардлагаар” жирийн хотуудын тоо ч эрс олширчээ. Хотуудад гар үйлдвэрлэл, худалдаа арилжаа хөгжихийн зэрэгцээгээр улс төр, нийгэм, соёлын олон объектууд байршиж эхэлжээ.

XII зуунаас эхлэн Европын хотуудад их сургуулиуд, баячуудын хүүхдүүдийн, шашны сургуулиуд, ном хэвлэл зэрэг өргөжиж, нийгэм соёлын хөгжил ч түргэсжээ (Харари, 2011). Тэр үеийн жижиг хотууд 500-4000 хүн амтай, худалдааны болон гар үйлдвэрлэлийн төвүүд 20000-40000 хүн амтай байжээ. Улсын нийслэлүүд нь 100-200 мянган хүнтэй болж өргөжжээ.

Тэр үеийн хотууд нь засаг захиргааны хувьд бүрэн биеэ даасан нэгжүүд хэлбэрээр хөгжиж, ирээдүйн эдийн засгийн хөгжлийн төвүүд болон хувирсан түүхтэй. Нөгөө талаар баруун Европын шашин шүтлэг ялангуяа христийн шашны нэгэн урсгал болох протестант шашин зах зээлийн эдийн засгийн хөгжлийг дэмжих чухал хүчин зүйл болсон.

Дундад зууны төгсгөл үед феодализм хэмээх нийгмийн байгууллын тулгуур хүчин байсан хамжлагат ёсыг халах олон түмний тэмцэл хөдөлгөөн Европын олон улс гүрнүүдэд өрнөсөн. Дундад зуунд хүн нийгмийн соёл иргэншил, ялангуяа эдийн засгийн

хөгжилд олон таатай хүчин зүйлүүд өрнөсөн боловч хувь хүний хөгжлийг саатуулж, хувь хүмүүс улс төрийн эрх мэдэлгүй, хамжлагат ёсонд хүлэгдэж байсныг дийлэнх хүмүүс ялангуяа, боловсролтой чөлөөт хүмүүс ухааран ойлгож сэргэн мандалт, ренесансын үеийг эхлүүлсэн түүхтэй. Франц улсад XVIII зууны эхэнд Наполеоны кодекс хэмээх улс төрийн актаар Францын тариачдыг хамжлагат ёсноос чөлөөлж тэдгээрийн ажиллаж байсан газрыг өвлүүлэн өмчлөх эрхээр хангасан нь феодализмын эдийн засгийн үндэс суурийг бүрмөсөн устгаж, феодализмын ноёрхол хүн нийгмийн туулж өнгөрүүлсэн түүхийг бий болгосон билээ.

Дундад зууны хүн нийгмийн туулж өнгөрүүлсэн нийгмийн түүхэн замналын хүрэн дотор өрнөсөн улс гүрнүүдийн хоорондох дайн байлдаан, байгаль орчны томоохон аюулт гаж үзэгдлүүд, гэнэтийн хүйтрэлт, бага мөстөлтүүд, тахал өвчин дэгдэлт, галт уулуудын дэлбэрэлт зэрэг таагүй үйл явдлууд нь дэлхий нийтийн эдийн засгийн хөгжил дэвшлийн үлэмжхэн потенциалыг бүрэн ашиглах боломжийг олгоогүй нь үнэнтэй.

Азийн орнуудын ялангуяа дундад зууны үеийн Хятад, Энэтхэгийн эдийн засгийн хөгжил дэвшлийн түүхэн замнал ч мөн чанар, утга агуулгаар Европтой бараг ижилдүү байсан. Дундад зуунд эдгээр том орнуудад эдийн засгийн хөгжлийн давуу тал гэхүйц шинэ хүчин зүйлүүд хэрэгжиж нэвтэрсэнгүй. Феодалын нийгмийн харилцаа мөн чанарын хувьд гол үйлдвэрлэгчид болох тариачид, гар үйлдвэрлэгчдэд эрх чөлөө олгосонгүй. Энэтхэгт кастын систем ноёрхож, Хятадад төвлөрсөн хаант засаглал эдийн засгийн хөгжлийн дарамт, тушаа болсон хэвээр байв. Гэхдээ эдгээр улсуудад хүн амын тоо асар олон хэвээр байсан ба хүн амын өсөлт нь үргэлжилсээр байсан тул дэлхийн үйлдвэрлэл, эдийн засагт тэдгээрийн эзлэх байр суурь нь бараг өөрчлөгдсөнгүй. Хятад, Европыг холбосон торгоны зам дундад зуунд Хятадын эдийн засгийн ерөнхий потенциалыг хадгалж үлдээх, дэлхийн эдийн засагт эзлэх байр суурийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Дундад зууны үеийн Монголын эзэнт гүрэн торгоны замыг устгаж сөнөөсөнгүй, харин хамгаалж, дэмжигчийн үүргийг гүйцэтгэж Хятадын эдийн засгийн тэлэлтэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Дундад зуун эдийн засгийн хөгжлийн хувьд Азийн хоёр том гүрэнд улс төр, цэрэг дайны давуу талыг буй болгож чадаагүй учир дэлхийн геополитикийн зураглалд өөрчлөлт оруулаагүй гэж үзэж болно. Хувилай хааны үеийн Хятад улс хоёр ч удаа Япон улсад халдан довтолж, байлдан дагуулах бодлого явуулсан боловч тэр үеийн Хятадын эдийн засгийн ерөнхий түвшин дорой, хоцрогдмол байдал зэрэг шалтгааны улмаас тэнгисийн цэргийн флот нь Япон тэнгисийн шуурга, хар салхинд нэрвэгдэж, устаж үгүй болсон түүхтэй.

Дундад зууны сүүлч үед, соён гэгээрэл боловсролын тэсрэлт хэлбэрийн хөгжлийн нөхцөлд нийгэм эдийн засгийн хөгжлийг түргэсгэх болон эдийн засагт нөлөөлөх шинэлэг хүчин зүйлүүдийн талаар сэтгэгчид, философичид олон хувилбар парадигмуудыг дэвшүүлж байжээ. Эдийн засгийн талаар нийгмийг бүхэлд нь хамарсан ухаарал бол хөдөө аж ахуйг бүтээлч үйл ажиллагаатай, баялаг бүтээгч салбар мөн тул түүний хөгжил тэлэлтэд л гол анхаарлаа хандуулах ёстой гэдэг үзэл байв.

2. Капитализмын үүсэл ба капиталын хуримтлал

Дундад зууны сүүлч үеэс эхлэн Европт хөдөө аж ахуйн зэрэгцээгээр гар үйлдвэрлэл түргэн хөгжиж олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ эрхлэх болсон нь хөдөлмөрийн хуваарь хэмээх эдийн засгийн хөгжлийн шинэ үзэгдлийг өргөжүүлж, дагналт ба хоршооллын процесс өргөн дэлгэрчээ. Дагналтын процесс нь аливаа нэгэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх олон үйлдэлт процессыг үйлдвэрлэлийн бие даасан хэлбэрт шилжүүлж, ажилчдыг зөвхөн энэхүү дагнасан, төрөлжсөн ажиллагаанд мэргэшүүлэн, тусгай зориулалтын багаж хэрэгслээр хангах болсон нь хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд үлэмжхэн тус дэм болжээ. Эдгээр үйлдвэрлэлүүд яваандаа капиталист үйлдвэрлэлийн шинж агуулгатай болж, шинэ техник технологийг өргөн хэрэглэх капиталын цар хүрээг түргэн тэлж хөгжүүлсэн билээ.

Ийнхүү капиталист үйлдвэрүүд дээр үйлдвэрлэлийн зардлын үлэмжхэн хэсгийг капитал зарцуулалт эзлэх болж үйлдвэрийн эзэд ажилчдад цалин хөлс олгохын зэрэгцээгээр өөрийнхөө капиталыг нөхөн сэргээх зардлыг бүтээгдэхүүн, таваарын үнэ, өртөгт шингээх болжээ. Мөн өөрийн хувийн амьдралын хэрэгцээт зардлыг үйлдвэрлэлийн зардалд хамааруулдаг жам ёс түгээмэл болжээ.

Капиталист үйлдвэрлэлийн онцлог нь аливаа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн борлуулахдаа үйлдвэрлэлийн процессын үед гарах бүх зардлыг бүрэн нөхөхийн зэрэгцээгээр нэмэгдэл болгон зохих хэмжээний өртгийг хавсаргадаг болжээ. Тэр үед энэхүү нэмэгдлийг нэмүү өртөг хэмээн нэрлэдэг байсан бөгөөд эдийн засгийн хэллэгээр “маржин (margin)” гэсэн ойлголт юм. Өөрөөр хэлбэл капиталист үйлдвэрүүд өөрийнхөө үйлдвэрлэн бүтээсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бусдад худалдан борлуулахдаа үйлдвэрлэлийн бүх зардал дээр маржиныг хавсаргадаг байжээ. Энэхүү бизнес, эдийн засгийн харилцааны хэлбэр нь зах зээлийн эдийн засгийн мөн чанарын илрэл мөн.

Капитализмын эхлэлийг капиталын анхны хуримтлалын үе хэмээн нэрлэдэг бөгөөд бараг хагас зуун жил үргэлжилсэн зөрчил тэмцлээр дүүрэн цаг үе байжээ. Капиталын хуримтлал, өсөлтөд шаардагдах хөрөнгө мөнгө, асар ховор нөөц байсан бөгөөд үүнийг ихэнх төлөвтөө үйлдвэрийн эзэд капиталын дотоод хуримтлалын (өөрийн хөрөнгийн) эх үүсвэрээр хангаж иржээ. Капитал ч дотоод бүтцийн хувьд хялбар, хямддуу, гол төлөв ажил үйлдвэрлэл явуулахад шаардлагатай орон байр, энгийн багаж хэрэгсэл төдийхөн байжээ. Энэ үед капиталын бүрэлдэхүүнд хүн хэмээх капиталыг хамааруулан үнэлэх хүмүүс тун цөөн байсан нь ойлгомжтой. Зарим тохиолдолд капиталистууд ажилчдын цалин хөлсийг амьжиргааны түвшингээс ч доогуур хэмжээнд олгодог буюу мөлжлөгийн хэлбэр байсан нь ч үнэнтэй. Мэдээж энэ байдлаас шалтгаалан ажилчид капиталистуудын хооронд зөрчил гарах нь зүйн хэрэг юм.

XIX зууны дунд үед капиталын анхны хуримтлалын процесс бүрэн дуусаагүй энэхүү хүнд үеийн ажилчид капиталистуудын хоорондын зөрчлийг ажигласан Карл

Маркс ангийн тэмцлийн тухай болон капитализм-ирээдүйгүй, сөнөх тавилантай эдийн засгийн систем гэсэн номлолыг дэвшүүлсэн билээ.

Гэхдээ л дундаж зууны үед эдийн засаг хэмээх ойлголт бүрэн бүтэн хэлбэрээр, өнөөгийнх шиг утга агуулгаар төлөвшиж чадаагүй. Ялангуяа, эдийн засгийн орчил эргэлтэд баялаг бүтээгчид, тариачдын ажил хөдөлмөр, үр дүн, оролцоог үнэлэх, илэрхийлэх боломжгүй байжээ. Дундад зууны төгсгөлд гар үйлдвэрлэл хэмээх аж үйлдвэрийн шинжтэй үйл ажиллагаа түгээмэл хэлбэртэй болж хөдөлмөрийн ба капиталын ач холбогдлыг ойлгох болж, улс орны баялаг бүтээгчид нийтээрээ эдийн засгийн харилцаанд хамрагдах болсон билээ. Эдийн засаг бүрэн төлөвшин хөгжихөд юуны өмнө баялаг бүтээгчид улс төрийн хувьд бүрэн эрх чөлөөтэй, ялангуяа ажил үйлсээ өөрийнхөө хувийн сонирхлын дагуу өөрөө сонгох чадвартай болох явдал байв.

Эдийн засгийн орчил эргэлтэд төр хэмээх институци чухал үүрэг гүйцэтгэх болж, эдийн засгийн харилцаанд шууд хэлбэрээр оролцох боломжгүй нийгмийн олон давхаргуудын оролцоог нэмэгдүүлжээ.

Улс гүрнүүдийн төр засгууд аж ахуй, бизнесийн нэгжүүдээс болон хөдөлмөрчин иргэдээс татвар төлбөрүүдийг хураан авах хэлбэрээр эдийн засгийн дахин хуваарилалтын системийг нэвтрүүлжээ. Үүний үр дүнд хүүхэд залуучууд, суралцагсад болон хөгшид тэтгэмж, тэтгэвэрт хамрагдах болж улс нийгмийн эдийн засгийн харилцаа болон эдийн засгийн эргэлтэд бүх нийтээрээ оролцох боломжтой болжээ. Энэ үеэс эхлэн хөгжингүй орнуудын бараг бүх иргэд эдийн засгийн харилцаанд хамрагдаж эдийн засгийн орчил эргэлт нь хөгжил дэвшлийн түвшинг тодорхойлох үзүүлэлтийн үүрэг гүйцэтгэн эдийн засагт ардчилал нэвтрэх илэрхийлэл болж чаджээ.

Үүнийг улс гүрнүүдийн эдийн засгийн нийт нөөц потенциалыг харуулах өнөөгийн ДНБ хэмээх статистик үзүүлэлтээс ажиглаж болно. Эдүгээгийн ДНБ-ий ерөнхий томъёолол нь (хэрэглээний аргаар)

$$GDP = C + I + G + X_n$$

C – иргэдийн хэрэглээ

I – бизнесийн хөрөнгө оруулалт

G – засаг, төрийн байгууллагуудын зардал

X_n – цэвэр экспорт

Чөлөөт өрсөлдөөнт зах зээлийн капитализмын үед иргэний хэрэглээ нь 60-70 хувийг эзэлж байсан тул улс орнуудын ДНБ дэх борлуулалтын хувь макро эдийн засгийн тэнцвэрийг хангахад голлон нөлөөлөх хүчин зүйл болжээ.

Ерөнхийдөө эдийн засгийн капиталист хөгжлийн зам нь капиталын хуримтлал, капиталын цар хүрээний өсөлт тэлэлтийн хэлбэрээр амьдрал дээр хэрэгжсэн билээ. XVIII, XIX зууны аж үйлдвэрийн гурван хувьсгалын ололт амжилт нь капиталын хуримтлалын процесстой нягт холбоотой бөгөөд эдгээр хувьсгалууд нь эргэх холбооны харилцан хамаарлын зарчмаар дэлхийн эдийн засагт капитал хэмээх хүчин зүйлийг улс нийгмийн голлох түгээмэл нөөц болоход эерэг нөлөөлжээ.

Капитал хуримтлалын эерэг ач нөлөөгөөр дэлхийн эдийн засаг олон салбартай болж хүн нийгмийн амьдралын түвшин мөн олон хэлбэрээр эрс дээшилсэн. Хэрэв шинэ тооллын эхний мянган жилийн турш хүн нийгмийн амьдрал зөвхөн хөдөө аж ахуй хэмээх ганц төрлийн эдийн засгаас хамааралтай байсан бол XX зуунд хөгжингүй орнуудын хөдөө аж ахуйд нийт ажиллагсдын зөвхөн 2-3 хувь нь ажиллаж хөдөлмөрлөх болж улс нийгмийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хэрэгцээг бүрэн хангах бүтээмж потенциалтай болжээ.

Капитализмын эдийн засгийн хөгжил, ялангуяа капиталын хуримтлал дэлхийн улс орнуудад тэдгээрийн боломж потенциалгаас шалтгаалан харилцан адилгүй хэлбэр, замаар хэрэгжсэн буюу өөрөөр хэлбэл, дэлхийн улс орнуудын капиталын хуримтлалын төвүүд газар зүйн хувьд ихээхэн өөрчлөгдөж байсан гэсэн үг юм. Эрдэмтдийн судалгаагаар дэлхий даяар капиталын хуримтлалын 4 мөчлөг хугацааг онцгойлон тэмдэглэдэг. Анхны цикл нь XV-XVII зууны эхэн үе хүртэлх зуу гаруй жил Италийн хойд хэсэгт хэрэгжсэн ба дараа нь Голландын (XVIII зууны эцэс хүртэл), гуравдугаар мөчлөг нь Английнх (XX зууны эхэн хүртэл), дөрөвдүгээр мөчлөг нь XX зууны турш үргэлжилсэн Америкийнх хэмээх нэршилтэй хэрэгжжээ.

Хүснэгт2. Дэлхийн хөгжингүй орнуудын эдийн засгийн хөгжилт үзүүлэлтүүд

	1700	1820	1998	Өсөлтийн хурд (дахин)
Хүн амын тоо /сая хүн/	110	175	838	7.6
Дотоодын нийт бүтээгдэхүүн /млрд 1990 оны доллароор/	100	198	17990	179.9
Нэг хүнд ноогдох ДНБ /млрд доллар/	907	1130	21470	23.7

Дээрх хүснэгтээс харвал дэлхийн хөгжингүй орнуудын

1700-1820 онд

- Хүн амын тоо 59 хувиар
- ДНБ-ний үйлдвэрлэл - 98 хувиар
- Нэг хүнд ноогдох ДНБ- 24,5 хувиар өссөн бол

1820-1998 онд

- Хүн амын тоо - 4,78 дахин
- ДНБ үйлдвэрлэл - 90,8 дахин
- Нэг хүнд ноогдох ДНБ 19 дахин өсөж,

эдийн засгийн цар хүрээ, өсөлтийн хурдцын үзүүлэлтүүдэд гайхмаар амжилтууд гарчээ. Нөгөө талаар дэлхийн хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлтийн үзүүлэлтүүд ч энэ хугацаанд сайжрах хандлагатай болжээ. Эдгээр орнуудын ДНБ-ний үйлдвэрлэлийн өсөлт 1700-1820 онд нийтдээ 83 хувь байсан бол 1820-1998 оны хугацаанд бараг 32 дахин өссөн ба нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ 1700 онд дунджаар 550 орчим доллар байсан бол 1820 онд 866 доллар, 1998 онд 5100 орчим доллар болж өсжээ (Maddison, 2001).

Эдүгээ, дэлхий даяар эдийн засгийн хөгжил дэвшлийн дараачийн эрин үе эхлэх төлөвтэй байгаа бөгөөд капиталын хуримтлалын эдгээр үе шатууд нь дотроо материаллаг үйлдвэрлэлийн хүрээнээс хальж мөнгө санхүүгийн системийн ноёрхол болон хувирч соёл иргэншлийн бусад олон илрэлүүд нөлөөлөх хандлага ажиглагдана.

Эдүгээ, чөлөөт зах зээл, хувийн өмчийн хүрээнд өрнөж ирсэн капиталын хуримтлал, эдийн засгийн хөгжил нь зах зээлийн системийн зохицуулах механизмуудын дутагдлаас шалтгаалан, асар олон шинэ төрлийн саад бэрхшээл эрсдэлүүдтэй тулгарах болов.

3. Мэдээллийн эрин үе дэх дэлхийн эдийн засгийн өөрчлөлт

Мэдээллийн технологийн үеийн эхлэлийг 1960-аад оноос компьютерыг бизнесийн хүрээнд өргөн ашиглаж эхэлснээр тооцдог бөгөөд 1990-ээд онд интернэтийг хүн нийгмийн бүхий л амьдралд хэрэглэх болсноор төгс хөгжлийнхөө замд шилжин орсон хэмээн үздэг.

Мэдээллийн технологийн үеийн амжилт ололтуудыг аж үйлдвэрийн хувьсгалуудын үр дүнтэй зэрэгцүүлэн үзвэл дэлхийн эдийн засагт нөлөөлөх эерэг талууд нь харьцангуй бага, ерөнхийд нь дүгнэвэл хүн төрөлхтний эдийн засгийн цаашдын хөгжлийн нөөц потенциал шавхагдаж, ялангуяа байгалийн нөхцөлтэй холбоо бүхий эерэг нөлөөллүүд багасах хандлагатай болжээ. Юуны өмнө дэлхийн хөгжингүй орнуудын хүн амын хөгшрөлт хэмээх урьд өмнө ажиглагдаагүй үзэгдэл өргөжих хандлагатай болсон ба хүн амын төрөлтийн үзүүлэлтүүд таатай бус хэлбэрт шилжиж “baby boom”-ийн үзэгдэл дахин эргэж ирэхгүй хандлага ажиглагдаж байна.

Ихэнх улс орнуудад иргэдийн орлогын медианы өсөлт дундаж орлогын өсөлтөөс хоцорч, тэдгээрийн эдийн засгийн оролцооны үзүүлэлтүүд доошлох хандлага ажиглагдах боллоо.

Берклигийн судалгаанд дурдсанаар хоёр зууны зааг дээр (1993-2008 онд) Америкийн иргэдийн гэр аж ахуйн орлого дунджаар жилд 1,3 хувир өссөн боловч тэдгээрийн 99 хувийн орлого нь зөвхөн 0,75 хувиар нэмэгджээ.

Баялаг санхүүгийн хувьд улс гүрнүүдийн хоорондын ялгаа улам гүнзгийрч, улс орон доторх иргэдийн орлого, хуримтлагдсан баялгийн хэмжээ мөн эрс ялгаатай болох төлөвтэй байна. Ялангуяа одоогийн дэлхийн эдийн засгийн өсөлтийн тоон үзүүлэлтийн бараг 60 хувийг хангадаг хөгжиж буй эдийн засгуудын сэргэн мандах найдвар тун бага боллоо.

Дэлхийн улс орнуудын эдийн засгийн ерөнхий шинж байдал өөрчлөгдөж, чөлөөт өрсөлдөөний зах зээлийн хэлбэрээс монополиудын ноёрхол голлосон, төрийн оролцоо эрс нэмэгдсэн макро эдийн засгийн загвар руу шилжих хандлага ажиглагдаж байна. Энэ нь мэдээллийн, үйлчилгээний эрин үеийн техник технологийн хөгжлийн асар өндөр түвшинтэй холбоотой. Нөгөө талаар хүрээлэн буй байгаль орчны нөхцөл байдал эрс доройтож, байгалийн гамшигт үзэгдлүүдийн хор хөнөөл ихэсч нийгмийн эдийн засагт үзүүлэх дарамт нэмэгдэх хандлагаас шалтгаалж байна. Өөрөөр хэлбэл, орчин үеийн эдийн засгийн үйл ажиллагааны далайц, цар хүрээ нь чөлөөт өрсөлдөөний зах зээлийн оролцогч субъектүүдийн боломж, потенциалас үлэмжхэн хэтэрсэн хэрэг юм.

Орчин үеийн эдийн засгийн үйл ажиллагааны практик дээр олон төрлийн дагнасан, үлэмжхэн том цар хүрээний капитал шаардсан эдийн засгууд бүрэлдэн тогтжээ. Дэлхийн бараг бүх улс орнуудад эрчим хүчний шинэ, ногоон эдийн засаг, дайн байлдааны ба батлан хамгаалахын, сансрын, хиймэл оюун ухаан, супер компьютер, квантын тооцооллын эдийн засгууд дагнасан хэлбэрээр бүрэлдэн тогтож, том монополь бизнес ба төрийн зүгээс ихээхэн нөөц, хөрөнгө мөнгийг шаардах боллоо. Эдүгээ дэлхийн томоохон, хөгжингүй орнуудын төр засаг өрийн дарамтад оржээ. Тухайлбал, Америкийн төрийн өр нь жилийн ДНБ-ний хэмжээнээс үлэмжхэн давжээ.

4. Дүгнэлт

Дэлхий даяар тэрбумтануудын тоо, тэдгээрийн санхүүгийн потенциал түргэн өсөх хандлагатай болжээ. 2024 онд 2800 шахам тэрбумтануудын хөрөнгө нийт дүндээ 15 их наяд долларт хүрсэн. Тэрбумтануудын хөрөнгийн 60% нь өв дамжин шилждэг ажээ (Annie Thériault, 2025). Эдгээрийн зэрэгцээгээр улс гүрнүүд дамнасан том хүчирхэг монополиудын тоо ч нэмэгдсэн байна. Америкийн жишгээр үзвэл топ долоогийн том монополууд Alphabet, Microsoft, Amazon, Nvidia, Meta, Tesla, Apple зэрэг нь тус бүр дунд зэргийн улс гүрний эдийн засагтай тэнцэхүйц үнэлгээ эдийн засгийн потенциалтай болжээ. Эдгээр байдлаас шалтгаалан дэлхийн эдийн засаг шинэ зууны эхлэлтэй зэрэгцэн хямралт байдалд байнга автагдаж эхэллээ.

Бүх улс орныг хамарсан 2008-2009 оны санхүүгийн хямрал, 2019 оны халдварт Ковид-19, 2023 оноос эдүгээг хүртэл үргэлжилсээр буй полиперма хямрал, 3 жил гаран үргэлжилсэн Орос, Украйны дайн, Израйль Хамаасын дайн зэрэг нь дэлхийн эдийн засагт тасралтгүй үргэлжилсэн дарамт болов. Мөн эдгээрийн зэрэгцээгээр байгаль орчны доройтолтой холбоотой гамшигт үзэгдлүүдийн давтамж олширч хор хөнөөлийн цар хүрээ ч өссөөр байна.

Эдүгээ, дэлхийн эдийн засгийн өсөлтийн хурдац саарах хандлага ажиглагдаж дэлхийн эдийн засгийн өсөлт 2025, 2026 онд 3.3 хувь байх төлөвтэй байгаа нь түүхэн (2000-2019) дунджаас 3.7 хувиар доогуур байна (World Bank Group, 2025). Шинжээчдийн дүгнэснээр Америкийн Нэгдсэн Улсын ерөнхийлөгч Трампын эхлүүлсэн тарифын дайн нь эдийн засгийн өсөлтийн хурдцыг 0.5 хувиар багасах тооцоо гарчээ (OECD, 2025).

НОМ ЗҮЙ:

- Annie Thériault, J. M. (2025 оны January 20). <https://www.oxfam.org/>.
<https://www.oxfam.org/en/press-releases/billionaire-wealth-surges-2-trillion-2024-three-times-faster-year-while-number-ээс Гаграсан>
- Gordon, R. J. (2012). IS U.S. ECONOMIC GROWTH OVER? FALTERING INNOVATION CONFRONTS THE SIX HEADWINDS. *NBER WORKING PAPER SERIES, Working Paper 18315*. <https://doi.org/10.3386/w18315>
- Maddison, A. (2001). *The World Economy: A Millennial Perspective*. OECD.
<https://doi.org/10.1787/9789264189980-en>
- OECD. (2025 оны March 17). *Bloomberg.com*. Economics:
<https://www.bloomberg.com/news/articles/2025-03-17/trump-s-trade-wars-tip-world-to-slower-growth-faster-inflation-ээс Гаграсан>
- Skousen, M. (2001). *The Making Modern World Economy: The Lives and Ideas of the Great Thinkers*. London: M.E.Sharpe.
- World Bank Group. (2025). *Global Economic Prospects*. Washington: The World Bank.
<https://doi.org/10.1596/978-1-4648-2147-9>
- Абхижит Банержи, Э. Д. (2019). *Хүнд үеийн эдийн засаг*. Монсудар.
- Тойнби, А. Д. (2002). *Постижения историй*. М.Айрис пресс .
- Харари, Ю. Н. (2011). *Sapiens: Хүн төрөлхтний товч түүх* . Улаанбаатар: Мон Судар.